

САЛБАРЫН ХЯНАЛТЫН ГАЗРЫН МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ХЯНАЛТЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН АХЛАХ
ШИНЖЭЭЧ Б.БҮРЭНЖАРГАЛЫН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Үр дүнгийн үзүүлэлт			Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
		Шалгуур үзүүлэлт	Хүрэх түшин	Гүйцэтгэсэн ажил, хүрсэн түвшин /биелэлт хангалтгүй бол шалтгаан/		
	1	2	3	4	5	6
Нэг. ЯАМНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО						
Стратеги төлөвлөгөөний зорилго 1. Хяналт шалгалтын хууль эрхзүйн орчныг боловсронгуй болгох, бодлогын удирдамжаар хангах						
Зорилт 1.1. Хяналт шалгалтын үйл ажиллагааны эрх зүйн орчинг боловсронгуй болгоно.						
1.1.1	Харилцаа холбооны хуулийн нэмэлт өөрчлөлт оруулах ажлын хэсэгт орж ажиллах	Хуулийн нэмэлт өөрчлөлтийн эрх зүйн баримт бичгийн тоо	1	1. Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн ажлын хэсэгт ажиллаж 30 дугаар зүйлд 4 санал, дагалдах Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд 3 санал оруулж ажилласан. 2. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд 3 санал боловсруулж ЦХХХСайдын 2024 оны 3 сарын 28-ны 01/621 дугаар албан бичгээр ХЗДХСайдад	2024.01.02-2024.04.10	90

				хүргүүлсэн бөгөөд 2024 оны 6 дугаар сарын 05-ны өдөр УИХ-ын нэгдсэн чуулганаар батлагдсан.		
1.1.2	Харилцаа холбооны салбарт шинээр болон шинэчлэн боловсруулсан стандарт, норм дүрмийн төсөлд санал өгөх.	Стандарт, норм, дүрмийн төсөлд өгсөн саналын тоо	2	1. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарт мөрдөгдөж буй тайлбар толь, нэр томъёоны үндэсний стандартуудад үзлэг хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж “Шуудан холбоо.Нэр томъёо” MNS 0515:2022 /45 хуудастай/, Шуудангийн дугтуй. “Нэр томъёо. Ангилал. Хэмжилт” MNS 3963:2014 /8 хуудастай/ стандартуудыг судалж нэр томъёотой холбоотой 3, утга найруулгын 6 санал боловсруулж ажлын хэсгийн ахлагчид хүргүүлэв. 2. Харилцаа холбооны цамхгийн аянга зайлуулагч болон газардуулгыг нэг газардуулгын хүрээнд холбодог, зураг төсөлд тусад нь байхаар төлөвлөдөггүй, аянга хүлээн авагч, аянгын гүйдэл зайлуулагчийн кабель шугамыг цамхгийн үндсэн метал хийцээс тусгаарлагчгүй угсардаг зэрэг шалтгааны улмаас харилцаа холбооны тоног төрөөрөмж гэмтэх тохиолдол гардаг учир “Харилцаа холбооны цамхаг, антен, тоног төхөөрөмжийн аянга зайлуулагчийн техникийн шаардлага” стандартыг шинээр боловсруулах талаарх саналыг батлагдсан маягтын дагуу үндэслэл, хамрах, хүрээ, уялдаа холбоог тодорхойлж Бодлого төлөвлөлтийн газрын ахлах шинжээчид хүргүүлсэн.	2024.01.02-2024.04.10	100
1.1.4	Хяналт шалгалтыг хэрэгжүүлэх нэгжийн дарга, улсын байцаагчдын үнэмлэх, зардлын төсөв тооцоог боловсруулж Төрийн захиргааны удирдлагын газарт хүргүүлэх	Боловсруулсан баримт бичгийн тоо	1	1. Улсын ерөнхий байцаагчийн 1 ширхэг, ахлах байцаагчийн 9 ширхэг, улсын байцаагчийн 20 ширхэг үнэмлэхний хавтсыг Дэлбакс ХХК-д захиалан хийлгэж, бүртгэл хөтлөн улсын байцаагч нарт олгосон 2. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 479 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Хяналт шалгалтын баримт бичгийн загвар”-ын дагуу хяналт шалгалтын хэвлэмэл хуудсыг хэвлүүлэхээр 2024 оны 11 сарын 04-ны 07/916 дугаар албан бичгээр Архивын ерөнхий газарт захиалга өгч, 6 төрлийн 1200 ширхэг хэвлэмэл хуудсыг хэвлүүлж авсан.	2024.01.12-2024.02.16	100

1.1.6	Салбарын хяналт шалгалтын үйл ажиллагаанд мөрдөх хяналтын хуудсыг шинэчлэн боловсруулж батлуулах.	Шинээр боловсруулж батлуулсан баримт бичгийн тоо	4	ЦХИХХЯамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн А/153 дугаар тушаалаар Мэдээлэл, харилцаа холбооны салбарын хяналт шалгалтын үйл ажиллагаанд хэрэглэх 09.01 кодтой Мэдээлэл, харилцаа холбооны шугам сүлжээг шалгах хяналтын хуудсыг 1 дүгээр, 09.02 кодтой Барилга байгууламж, харилцаа холбооны шугам сүлжээний угсралтын ажлыг шалгах хяналтын хуудсыг 2 дугаар тус тус шинэчлэн батлуулсан.	2024.12.02-2024.12.09	90
1.1.5	Салбарын хяналт шалгалтад хамаарах объектын жагсаалтыг боловсруулж, салбарын сайдаар батлуулах.	Шинээр боловсруулж батлуулсан баримт бичгийн тоо	1	Засгийн газрын 2023 оны 420 дугаар тогтоолын дагуу Мэдээлэл, харилцаа холбооны салбарын 2024 оны төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдах объектын жагсаалт батлах тухай ЦХХХСайдын А/08 дугаар тушаалыг боловсруулж батлуулсан.	2024.01.12-2024.01.16	100
1.1.8	Сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хяналт шалгалтын байгууллага, улсын байцаагчдыг мэргэжил, арга зүй, зохион байгуулалтын удирдлагаар хангах.	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	1 сургалт	1. Аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар, Харилцаа холбооны зохицуулах хорооны мэдээлэл, харилцаа холбооны хяналтын 25 улсын (ахлах) байцаагчдыг хамруулан цахим хөгжил, харилцаа холбооны салбарын бодлого, чиглэл, хууль эрх зүй, мэргэжил, арга зүй, зохион байгуулалтын удирдлагаар хангах нэгдсэн арга хэмжээг 2024 оны 04 дүгээр сарын 03-наас 05-ны өдрүүдэд зохион байгуулсан. Тус сургалтад "Мэдээлэл, харилцаа холбооны хяналт, анхаарах асуудал", "2024 оны Улсын Их хурлын ээлжит сонгууль, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа" сэдвээр илтгэл тавьсан. 2. Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн сурталчилгааны хугацаанд Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 6.50 дахь заалтын хүрээнд Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 14, 15, 17, 20 дахь хэсэгт заасан зөрчилд Мэдээлэл, харилцаа холбооны хяналтын улсын байцаагч шалган шийдвэрлэх ажиллагааг явуулахаар харьяаллыг тогтоосны дагуу радио, телевиз, цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах үйл ажиллагаанд хяналт тавих	2024.04.03-2024.12.06	100

				чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Нийслэл, аймгийн нийт 15 улсын байцаагч нарт шуурхай мэдээлэл солилцох, гомдол, мэдээлэл ирсэн тохиолдолд удирдлага зохион байгуулалтын хувьд хэрхэн ажиллах талаар цахим сургалтыг 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдөр зохион байгуулсан.			
Хоёр. ЯАМНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛТ							
6.2. Салбарын хяналт шалгалтыг хэрэгжүүлэх замаар хууль тогтоомж, техникийн зохицуулалт, норм, стандартын хэрэгжилт, харилцаа холбоо, мэдээллийн технологийн ашиглалт, үйлчилгээний тасралтгүй, хэвийн, найдвартай, аюулгүй ажиллагааг хангуулах							
Зорилт 2.1. Мэдээлэл, харилцаа холбооны сүлжээ, үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанаас үүсэх эрсдлийг ухаалгаар удирдана.							
2.1.2	Хяналт объектуудад үнэлгээ хийх.	шалгалтын эрсдлийн	Хяналт шалгалтын нийт объектод эрсдлийн үнэлгээнд хамрагдсан объектын эзлэх хувь	100 хувь	Хяналт шалгалтын бүртгэл мэдээллийн нэгдсэн систем (http://shilenkhyanalt.gov.mn/)-д Мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгч этгээдийг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур үзүүлэлтээр 108 объектод эрсдлийн үнэлгээ хийсэн.	2024.11.10-2024.11.25	95
Зорилт 2.2. Хяналт шалгалтын үйл ажиллагааны үр дүн, бүтээмжийг дээшлүүлнэ.							
2.2.1	Хяналт шалгалтын объектын эрсдэлийн үнэлгээг хийн, их, дунд эрсдэлийн ангилалд хамаарах объектуудад төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалт хийх.	Хууль сахин мөрдөлт /хувь/		78	1. Монголын цахилгаан холбоо ХК-д 09-00/10 дугаар, Радио телевизийн Үндэсний сүлжээ УТҮГ 2024 оны 07 дугаар сарын 08-ны 09-00/11 дугаар, Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-д 09-00/12 дугаар, Монгол шуудан ХК 09-00/13 дугаар, Юнивишн ХХК-д 09-00/15 дугаар төлөвлөгөөт хяналт шалгалт хийх удирдамжийн дагуу төв, 6 аймгийн салбар нэгжийн нийт 25 объектод хяналт шалгалт хийж гүйцэтгэн танилцуулга гаргаж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах зорилгоор 148 заалт бүхий 23 улсын ахлах байцаагчийн албан шаардлага хүргүүлж ажилласан. Хяналтын хуудсаар эрсдэлийг үнэлэхэд хууль сахин мөрдөлт 78,2 хувьтай, Эрсдэл үүсэх магадлал 27,8 хувьтай үнэлэгдлээ. Юнивишн ХХК-ийн шалгалт үргэлжилж байна. 2. Тоон гарын үсгийн тусгай зөвшөөрөлтэй 3 аж ахуйн нэгжид хяналт шалгалт хийж, шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах зорилгоор “Монпасс СА”	2024.05.01-2024.12.05	95
		Эрсдэл үүсэх магадлалын бууралт /хувь/		28			

				ХХК-д 2 заалт бүхий 09-00-02/001/02 дугаар, "Нью Компасс" ХХК-д 3 заалт бүхий 09-00-02/001/03 дугаар улсын ахлах байцаагчийн албан шаардлага гаргаж хүргүүлэн зөрчил, дутагдлыг бүрэн арилгуулсан.		
2.2.2	Гадаадын зээл тусламж, төсөл хөтөлбөр, улс, орон нутгийн төсөв, бусад хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа харилцаа холбооны барилга байгууламж, шугам сүлжээний зураг төсөл, угсралтын ажлын чанар, техникийн аюулгүй байдлыг хангуулах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх.	Зөрчил арилгуулалт /хувь/	79	1. Цахим хөгжил, харилцаа холбооны салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 09-00/06 дугаартай урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай удирдамжийн хүрээнд харилцаа холбооны дэд бүтцийн байгууламжийн зураг төсөл, угсралтын байдалд Төрийн нарийн бичгийн даргын А/124 дугаар тушаарлын дагуу 2024 оны 5 дугаар сарын 22-ноос 6 дугаар сарын 05-ны өдрүүдэд томилолтоор ажиллаж Ховд аймгийн Алтай сумын 1 дүгээр баг Бодонч, Мөнххайрхан сумын 2 дугаар баг Борт, 3 дугаар баг Хаг, Дуут сумын 3 дугаар баг Цагаан бургас, Мөст сумын 3 дугаар баг Баянхайрхан, Булган сумын 2 дугаар баг Баянсудал зэрэг газарт баригдах үүрэн холбооны дахин дамжуулах станцын байр, 20 метр өндөр холбооны цамхгийн зураг төсөл, угсралтын байдалд үзлэг шалгалтыг хийж гүйцэтгэн холбогдох зураг төсөл, стандарт норм дагуу хийх талаар нийт 6 хугацаатай үүрэг даалгаврыг өгсөн ба зөрчлийг 100 хувь арилгуулан ажилласан. 2. Мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх зөвшөөрөл бүхий 29 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж гүйцэтгэн танилцуулга гаргаж холбогдох удирдлагуудад танилцуулсан. Шалгалтын дүнгээр холбогдох аж ахуйн нэгж байгууллагад зөвлөмж өгч ажилласан бөгөөд хэлэлцүүлэг зохион байгуулсан.	2024.05.01-2024.09.05	100
2.2.3	Мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмжийг баталгаажуулах зөвлөлд ажиллах	Хянан баталгаажуулах үйл . ажиллагааны хэрэгжилт, хувь	100	Мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмжийг баталгаажуулах зөвлөлийн гишүүнээр ажиллаж 2024 оны эхний хагас жилд нийт 22 хуралд оролцож 389 тоног төхөөрөмжид баталгаажилтын гэрчилгээг 3 жилийн хугацаатай шинээр олгож, 326 тоног төхөөрөмжийн хугацааг 3 жилийн хугацаагаар сунгаж ажиллав.	2024.02.10-2024.12.05	100

2.2.4	Харилцаа холбооны стандартчиллын техникийн хороонд ажиллах	Батлагдсан стандартын тоо	4	1. Стандартчилал, хэмжил зүйн газрын даргын 2023 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн А/06 дугаар тушаалын дагуу "Харилцаа холбооны стандартчиллын техникийн хороо"-ны гишүүнээр ажиллаж 2024 оны 1 дүгээр хуралд оролцож, шинэчлэн боловсруулсан 3, шинээр боловсруулсан 4 нийт 7 стандартын төсөлтэй танилцаж стандартын нэр томьёо, агуулгатай холбоотой 4 саналыг тусгуулахаар хурлын тэмдэглэлд тусгав. 2. Харилцаа холбооны стандартчилалын техникийн хорооны гишүүнээр ажиллаж 2025 онд шинээр болон шинэчлэн боловсруулах стандартын төлөвлөгөөнд онооны системийн дагуу санал өгч d.dolgorsuren@crc.gov.mn цахим шуудангаар техникийн хорооны даргад хүргүүлсэн.	2024.02.10-2024.12.05	100
2.2.5	Төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, урьдчилсан сэргийлэх хяналт шалгалтын удирдамж боловруулж батлуулах.	Батлуулсан удирдамжийн тоо	3	1. Монгол улсын Засгийн газрын 2024 оны 420 дугаар тогтоолын хавсралтаар баталсан хяналт шалгалтын төлөвлөгөөг үндэслэн Цахим хөгжил харилцаа холбооны яамны Салбарын хяналтын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд заасны дагуу 09-00/02 дугаартай төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай, 09-00/04, 09-00/07 дугаартай төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай, 09-00/06 дугаартай урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай, 09-00/15, 09-00/16, 09-00/17 дугаартай төлөвлөгөөт хяналт шалгалт хийх удирдамжийг тус тус боловсруулж, Салбарын улсын еранхий байцаагчаар батлуулан аймаг нийслэл дэх мэдээлэл, харилцаа холбооны хяналтын улсын байцаагчидад болон ХХЗХорооны хуулиар эрх олгогдсон улсын байцаагч нарт болон хяналт шалгалтад хамрагдах аж ахуйн нэгж байгууллалгад хүргүүлсэн. 2. Хөвсгөл аймгийн иргэн Б.Нэргүйгээс ирүүлсэн гомдлын дагуу Улсын ахлах байцаагчийн төлөвлөгөөт бус шалгалт хийх тухай 2024 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 09-00/03 дугаартай удирдамж баталж, Хөвсгөл аймгийн Мэдээлэл харилцаа холбооны хяналтын улсын байцаагчид хүргүүлсэн.	2024.01.04-2024.12.05	100

2.2.6	Мэдээлэл, харилцаа холбооны барилга байгууламж, шугам сүлжээг ашиглалтад оруулах улсын комисст ажиллах.	Улсын комиссоор өгсөн үүрэг даалгаврын биелэлт /хувь/	83 хувь	Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийн Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын дохиолол холбооны систем, тетра тоон радио системийг хүлээн авах 2023 онд ажилласан техникийн комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг шалгаж, үүрэг даалгаврын биелэлт 100 хувь хангагдсан тул Техникийн комиссын дүгнэлтийг баталгаажуулсан.	2024.01.04-2024.01.15	95
2.2.7	Удирдлагаас өгсөн үүрэг, иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээллийн дагуу төлөвлөгөөт бус шалгалт хийх	Өргөдөл гомдлын шийдвэрлэлт /хувь/	98 хувь	“Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК-иас ирүүлсэн албан бичгийн дагуу Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 09-00/05 дугаартай төлөвлөгөөт бус хяналт шалгалтын удирдамжийн хүрээнд Сноу филдс ХХК-ийн СХД-ийн 20 хороонд баригдаж буй үйлдвэрийн барилын сууринд харилцаа холбооны шугам сүлжээ орсонтой холбоотой хяналт шалгалтыг хийж, харилцаа холбооны шугам сүлжээний аюулгүй байдлыг бүрэн хангах, шинээр хийх худаг сувагчлалын угсралтын ажлыг техникийн нөхцөл, зураг төслийн дагуу стандарт, норм дүрмийн шаардлагад нийцүүлэн хийж гүйцэтгэх талаар Сноу филдс ХХК-д 09-00-02/001/01 дугаартай 2 заалт бүхий улсын ахлах байцаагчийн зөвлөмж гаргаж хүргүүлсэн.	2024.04.12-2024.04.29	100
2.2.8	Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг хууль, тогтоомжийн хүрээнд явуулах.	Зөрчил арилгуулалтын хувь	75 хувь	1. Нийслэлийн прокурорын газраас ирүүлсэн 1/260 дугаар албан бичгийн дагуу зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтны нэгдсэн судалгааг гаргаж niislelprozurchil@gmail.com цахим шуудангийн хаягаар хүргүүлсэн.	2024.03.10-2024.03.12	80
2.2.9	Салбарын гамшгаас хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих.	Өгсөн үүрэг даалгаврын биелэлт /хувь/	100	Улсын Онцгой Комиссын 2024 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн хуралдаанаас өгсөн үүргийн дагуу Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 26-р хорооны нутаг дэвсгэрт байрлах 4 барилга гал түймэрт өртсөнтэй холбогдуулан барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний төлөв байдал тогтоох, хийц бүтээцийн бат бэхийн чанарт лабораторийн туршилт, шинжилгээ хийж, үнэлгээ дүгнэлт өгөх, цаашид засварын ажилд шаардагдах төсвийг тооцох үүрэг бүхий ажлын хэсгийг БХБС-ын 2024 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 18 дугаар тушаал,	2024.01.31-2024.02.28	100

				Салбарын улсын ерөнхий байцаагч Д.Жаргалын баталсан 02-00/10 дугаар удирдамжийн дагуу 204, 207, 308, 206 дугаар байрны харицаа холбооны гадна шугам сүлжээ, барилгын дотор холбоо дохиоллын босоо болон 63 айлын хэвтээ шугам сүлжээ, төгсгөлийн тоног төхөөрөмжийн төлөв байдалд үзлэг шалгалт, хэмжилтийн ажлыг хийж гүйцэтгэн 4 танилцуулга бичиж, 4 ажлын хэсгийн нэгдсэн дүгнэлтэд нийт 8 заалт оруулж ажилласан.		
ГУРАВ. ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ						
3.1	Албан хаагчдын худалдан авах ажиллагаанд санал боловсруулж, ТЗУГ-т хүргүүлэх.	Худалдан авах ажиллагааны тоо	1	1. Цахим хөгжил, харилцаа холбооны яамны 2024 оны урсгал төсвийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд Салбарын хяналтын газраас хэрэгжүүлэх үйл ажиллагаа, арга хэмжээний саналыг болловсруулж Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэст хүргүүлсэн. 2. Цахим хөгжил, харилцаа холбооны яамны 2024 оны урсгал төсвийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд өөрчлөлт оруулж байгаатай холбоотой Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны А/262 тушаалд улсын байцаагчийн хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгсэлийг гамшгийн үед хэрэглэх үүргэвч болон түүний иж бүрдэлтэй нэгтгэсэн байгаа нь Төрийн хяналт шалгалтын тухай болон Гамшгаас хамгаалах тухай хуулийн холбогдох заалтын дагуу зориулалт өөр тул 2 хуваан салгаж өөрчлөлт оруулах саналыг боловсруулж Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэст хүргүүлсэн.	2024.01.02-2024.05.10	100
3.2	Төрийн албаны зөвлөл, байгууллагаас зохион байгуулж буй сургалтад тухай бүр хамрагдах	Хамрагдсан сургалтын тоо	5	Төрийн албаны зөвлөл болон байгууллагаас зохион байгуулсан цахим болон танхимын сургалтад нийт 18 удаа хамрагдаж хувь хүний хөгжил, төрийн албаны хууль эрх зүй болон мэргэжлийн мэдлэг чадвараа дээшлүүлсэн.	2024.01.02-2024.06.10	90
3.3	Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг	ХАСХОМ-ын тайлагналт	1 мэдүүлэг	Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн	2024.01.22-2024.02.01	100

	сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах			хүрээнд 2023 оны хөрөнгө орлогын мэдүүлгээ шинэчлэн гаргаж, байгууллагын эрх бүхий албан тушаалтанд хуулийн хугацаанд тайлагнаж баталгаажуулсан.		
3.4	Байгууллагын цахим болон дотоодын ээлжит, ээлжит бус шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангаж ажиллах	Тухайн жилд өгсөн үүрэг даалгаврын биелэлт /хувь/	100	Тайлант хугацаанд өгсөн үүрэг даалгаврыг тухай бүрт биелүүлж, 100 хувьтай хэрэгжүүлсэн ажиллсан байна. Үүнд: 1. Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын аймгийн хэлтсийн дарга нарын сургалтад зориулж Мэдээлэл, харилцаа холбооны салбарын хяналтын газрын чиг үүрэг сэдвээр танилцуулга бэлдэв. 2. Цахим хөгжил, харилцаа холбооны сайд болон аймгийн засаг даргын хооронд 2024 онд хамтран ажиллах гэрээний төсөлд Салбарын хяналтын газрын үйл ажиллагаатай холбоотой 3 заалтад санал өгч, боловсруулав. 3. Харилцаа холбооны зохицуулах хорооноос 2024 оны 5 дугаар сарын 06-ны өдөр Улаанбаатар хотод үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй радио, телевизийн үйлчилгээ эрхлэгчид болон сайтуудын дунд зохион байгуулсан сонгуулийн үйл ажиллагаатай холбоотой сургалтад “Монгол Улсын Их хурлын 2024 ээлжит сонгуулийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах талаар авах арга хэмжээ, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа” сэдвээр мэдээлэл хийж, оролцогчдын сонирхсон асуултад хариулт өгч ажилласан. 4. Газрын даргаас өгсөн үүргийн дагуу Стандартчилал, тохирлын үнэлгээний хяналт, зохицуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй танилцаж 9 дүгээр зүйлийн 9.1, 9.1.2, 9.3.1 дэх заалт Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн холбогдох заалттай давхардсан болон зөрчилдөж байгаа тул хасах, ойлгомжтой байдлаар өөрчлөн найруулах 3 саналыг боловсруулж Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээчид өгсөн.	2024.01.14-2024.06.10	100
3.5	Салбарын хяналтын газрын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг ТЗУГ-т	Хүлээлгэн өгсөн архивын нэгж	2 баримт	1. Салбарын хяналтын газрын 2024 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг гаргаж газрын даргаар	2024.04.14-2024.05.21	90

	хүргүүлэх, баримт бичгийг байгууллагын архивт хүлээлгэн өгөх			хянуулан байгууллагын архив, бичиг хэргийн ажилтанд хүлээлгэн өгсөн. 2. 2023 оны хяналт шалгалтын холбогдох баримт бичгийг архивын нэгж болгон байгууллагын архив, бичиг хэргийн ажилтанд хүлээлгэн өгсөн.		
3.6	Олон улсын байгууллага, гадаад орнуудын ижил төстэй байгууллагатай гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх	Хамтран ажиллаж буй байгууллагын тоо	1	Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага ЖАЙКА болон Цахим хөгжил, харилцаа холбооны яамтай хамтран хэрэгжүүлж буй Кибер аюулгүй байдлын хүний нөөцийг хөгжүүлэх техникийн хамтын ажиллагааны төслийн хүрээнд Япон Улсын яамд, кибер аюулгүй байдлын чиглэлийн холбогдох байгууллагууд болон онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй аж ахуйн нэгжүүдтэй танилцаж, төрийн байгууллагын кибер аюулгүй байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээ, шинээр кибер орчинд гарч буй аюул, заналхийллүүд, Монгол Улсын онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагуудыг хамгаалах, кибер аюулгүй байдлыг хангахад чиглэсэн шаардлагатай арга хэмжээг тодорхойлох зорилготой сургалтад оролцох зорилгоор Төрийн нарийн бичгийн даргын А/17 дугаар тушаалын дагуу 2024 оны 2 дугаар сарын 14-нөөс 21 өдрүүдэд Япон улсын Токио хотод томилолтоор ажилласан.	2024.02.14- 2024.02.21	100

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

Д/д	Боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвараа сайжруулах арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.2	Арга хэмжээ №1. Мэргэжлийн зэргийг дээшлүүлэх зорилгоор магистарт дэвшин суралцах	Амжилттай суралцсан кредит цаг	-	10 багц цаг	ШУТИС-ийн Мэдээлэл холбооны технологийн сургуулийн магисрын сургалтад хамрагдаж Инженерийн загварчлал 2 кредит, Оюуны өмчийн харилцаа 2 кредит, Хиймэл оюун ухаан2 кредит, Судалгааны онол арга зүй 2	2024.01.20- 2024.12.05	100 %

					кредит, Эмбэдэд систем 3 кредит, Удирдлагын онол 3 кредит, нийт 5 хичээлийн 10 кредит цагийн сургалтад хамрагдаж амжилттай дүүргэсэн.		
1.3	Арга хэмжээ №2. Барилга байгууламжийн мэдээлэл холбооны зураг төслийн мэргэшлийн зэргийг сунгуулах сургалтад хамрагдах.	Богино хугацааны сургалтын хөтөлбөрт хамрагдсан байна.	-	5 багц цаг	1. Зураг төсөл зохиогчдын холбооноос зохион байгуулсан "Зөвлөх инженерийн ур чадвар" сэдэвт 5 багц цагийн сургалтад хамрагдаж Зөвлөх инженерийн зэрэг горилох шалгалтад хамрагдаж тэнцсэн. Одоо сэдвийн хамгаалалтад орохоор бэлтгэл ажлыг хангаж байна.	2024.02.22- 2024.03.22	100 %

ТАЙЛАН ГАРГАСАН:

МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ХЯНАЛТЫН

АСУУДАЛ ХАРИУЦСАН АХЛАХ ШИНЖЭЭЧ



Б.БҮРЭНЖАРГАЛ